



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар Б/49

Хэрлэн сум

Ж.Энхтөрд сахилгын
шийтгэл ногдуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 65 дугаар зүйлийн 65.3.2, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Сумын удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалтын ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх заалт, “Архигүй Дарханчууд” хөтөлбөрийн хүрээнд хийсэн худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн тул сахилгын хариуцлага тооцуулах тухай аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 253/A2370454, 254/A2370454 дүгээр албан шаардлагуудын дагуу Дархан сумын Засаг дарга Ж.Энхтөрд сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Дархан сумын Засаг дарга Ж.Энхтөрд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ